



I/2022


Тархаасан: 2022 оны 2 дугаар сарын 14



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх сараас 11.2 хувиар буурсан байна

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2022 оны 1 дүгээр сард урьдчилсан гүйцэтгэлээр 178.0 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 25.1 хувиар өсөж, өмнөх сараас 11.2 хувиар буурсан байна.

ЗУРАГ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100), сараар, хувь



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2022 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 25.1 хувиар өсөхөд уул уурхай, олборлолтын дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 30.6 хувиар (нүүрс олборлолтынх 65.7 хувь, газрын тос, олборлолтынх 72.4 хувь, металлын хүдэр олборлолтынх 10.1 хувь, бусад ашигт малтмал олборлолтынх 18.1 хувь) өссөнөөс шалтгаалсан байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2022 оны 1 дүгээр сард өмнөх сараас 11.2 хувиар буурахад уул уурхай, олборлолтын дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 13.3 хувиар (металлын хүдэр олборлолтынх 26.7 хувь) буурсан нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ДЭД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО, нэгж хувиар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

| Дэд салбар | 2020 I | | 2021 I | | 2022 I | |
|--------------------------------------------------------------------------------------------|------------|--------------|-------------|--------------|-------------|--------------|
| | хувь | нэгж хувь | хувь | нэгж хувь | хувь | нэгж хувь |
| Ерөнхий индекс | 8.8 | 100.0 | -1.1 | 100.0 | 25.1 | 100.0 |
| Уул уурхай, олборлолт | 7.0 | 80.0 | -2.0 | 173.0 | 24.4 | 97.2 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 0.6 | 7.0 | 0.7 | -63.2 | 1.2 | 4.7 |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 1.0 | 11.8 | 0.1 | -9.8 | -0.8 | -3.2 |
| Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 0.1 | 1.2 | 0.0 | 0.0 | 0.3 | 1.4 |

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 25.1 хувиар өсөхөд уул уурхай, олборлолтын салбарын үйлдвэрлэгчийн үнэ 24.4 нэгж хувь, боловсруулах үйлдвэрийн салбарынх 1.2 нэгж хувь усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарынх 0.3 нэгж хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, дэд салбараар, хувиар, 2022 оны 1 дүгээр сард

| Дэд салбар | Нийт жин | 2022* I 2015 | 2022* I 2021 I | 2022* I 2021 XII |
|--------------------------------------------------------------------------------------------|--------------|-----------------|-------------------|---------------------|
| | 2015=100 | | | |
| Ерөнхий индекс | 100.0 | 178.0 | 125.1 | 88.8 |
| Уул уурхай, олборлолт | 77.9 | 190.3 | 130.6 | 86.7 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 14.6 | 144.2 | 108.6 | 102.1 |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 6.7 | 103.9 | 86.0 | 93.7 |
| Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 0.8 | 209.1 | 142.2 | 123.1 |

Ойлголт, тодорхойлолт:

Үйлдвэрлэгчийн үнийн индекс: Тухайн үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн болон худалдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Индексийн жин: Индексийн тооцоонд ашиглах жинг тухайн бүтээгдэхүүний нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувийн жингээр тооцно.

Тооцох аргачлал:

Үйлдвэрлэгчийн үнийн индексийн тооцоонд Ласпейрсийн үнийн индексийг ашиглана. Үүнд:

$$I_p^t = \frac{\sum_{i=1}^n (p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^n (p_0^i * q_0^i)}$$

Үүнд:

I_p^t – t тайлант үеийн Ласпейрсийн үнийн индекс

t – тайлант үе

0 – суурь үе

p_t^i – i барааны тайлант үеийн үнэ

p_0^i – i барааны суурь үеийн үнэ

q_0^i – i барааны суурь үеийн худалдан авсан тоо



Эх үүсвэр:

ҮСХ, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн мэдээ

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал,
Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 3 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын Үнийн
статистикийн хэлтсийн статистикч Б.Энхтүвшин
Утас : (976-51)-261563

